



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/34

Бор-Өндөр

Гэр хорооллын айл өрхүүдийн гал түймрийн аюулгүй байдал урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.2 дахь хэсэг, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.3, 15.1.4 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний I дүгээр үе шатыг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 04 дүгээр сарын 30, II дугаар үе шатыг 10 дугаар сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд сумын хэмжээнд зохион байгуулсугай.
2. Хийгдэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
3. Арга хэмжээнд шаардагдах 1.035.000 (нэг сая таван зуун гучин таван мянган) төгрөгийг гамшгийн эрсдлийн сангийн хөрөнгөөс зардлаас гаргахыг Санхүү албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.
4. Мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Бор-Өндөр сум дахь Онцгой байдлын хэлтсийн дарга хошууч (Г.Мөнхнаран)-д даалгасугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Галбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ГАДЪЯАБИЛЭГТ